

БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

..... /АГАНЗУУЗАЙ/

2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр

АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ "УТААГҮЙ ДАЛАНЗАДГАД" АРГА  
ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ӨМДЗСЗДТГ/20240101031 ДУГААРТАЙ АЖЛЫН  
ДААЛГАВАР

| № | Агуулга   | Үзүүлэлт   |
|---|---|--|
| 1 | Баримт бичиг боловсруулах үндэслэл                    | Даланзадгад сумын ИТХурлын 2023 оны 13/10 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын 27 дугаар заалт, 13/9 дүгээр тогтоолын хавсралтын 2.6.82 дахь заалт,  |
| 2 | Байршил   | Өмнөговь аймаг, Даланзадгад сум, 6 дугаар баг, Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар   |
| 3 | Зориулалт, хүчин чадал                                | Даланзадгад сумын гар галлагаатай айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагын хэрэгцээнд шаардлагатай үндсэн түүхий эд болох 20,000 /хорин мянга/ тонн угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсний цэгийг бий болгох, нөөц бурдуулэх, иргэдэд тараах  |
| 4 | Ажлын цар хүрээ                                       | Ухаа худаг дахь "Энержи ресурс" ХХК-ийн нүүрс боловсруулах үйлдвэрээс Даланзадгад сумын гар галлагаатай айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагын хэрэгцээнд угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг тогтсон нүүрсний цэгээс, батлагдсан хэмжээгээр олгох, тараах ажлыг зохион байгуулах  |
| 5 | Ажил гүйцэтгэх хугацаа                                | Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.   |
| 6 | Ажлын захиалагч                                       | Даланзадгад сумын Засаг даргын Тамгын газар  |
| 7 | Ажил гүйцэтгэх, бичиг баримт боловсруулах байгууллага | Авто тээврээр ачаа тээвэрлэх ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллага, аж ахуйн нэгжүүд оролцох боломжтой   |
| 8 | Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд   | <ol style="list-style-type: none"><li>Барааг зөөвөрлөх үе шат бүрт биет байдлын ямар нэгэн хорогдолгүй, баталгаажуулсан даац /тн, жин/-даа хүрсэн зөөвөрлөх үйл ажиллагааг хариуцах</li><li>Гүйцэтгэгч угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрс тараах нүүрсний цэгтэй байх ба харуул хамгаалалт, тохижилт, ажиллах боловсон хүчинээр бүрэн хангагдсан байх.</li><li>Угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрс тараах цэгийн байршлыг баталгаажуулан ирүүлэх</li><li>Угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрс</li></ol> |

|  |  |   |
|--|--|---|
|  |  | <p>тараах цэгийн байршлыг тендерт шалгарсан оролцогч захиалагчтай зөвшилцэн байгуулна.</p> <p>5. Угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрс тараах цэг нь иргэдэд нүүрсийг тээвэрлэхэд ойр байх, замын аюулгүй байдлыг хангасан байх</p> <p>6. Угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг тасалдалгүй, тогтвортой нийлүүлэхийн тулд шаардлагатай машин техник хэрэгсэлтэй байх</p> <p>7. Угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг буух талбайд аль болох нягтаршилтай буулгах</p> <p>8. Нүүрс буух талбайд буусан угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг овоолох, нуруулдах, штамблах, иргэдийн тээврийн хэрэгсэлд ачих ажлыг хариуцан хийх</p> <p>9. Автомашины нүүрс тээвэрлэж ирсэн рейсийн тоог өдөр болгон тохирч явах</p> <p>10.Машин техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцан ажиллуулах мэргэжлийн боловсон хүчинтэй байх</p> <p>11.Дээрхи тээвэрлэлтийн ажил, нүүрс татан авалтын төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээний угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг тээвэрлэх, нүүрсний цэгт буулгах, тараах үе шатны ажлын хувиар, төсвийг гаргаж баталгаажуулан ирүүлэх.</p> <p>12.Нүүрс уг уурхайн угаасан бүхэллэг эсвэл шигшсэн дулааны зориулалтай бүхэл нүүрс байх бөгөөд тээвэрлэх явцад зориулалтын хучлагатай байвал зохино.</p> <p>13.Тээвэр хийх аж ахуйн нэгж нь НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн байх.</p> <p>14.Машин механизм тээврийн хэрэгсэлийн оношлогоонд орсон байх.</p> <p>15.Гэрээний хугацаанд нүүрсийг тасралтгүй нийлүүлэх</p> <p>16.Нүүрс тээврэлтийн үеийн аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, шаардлагатай даатгалыг тендерт оролцогч аж ахуйн нэгж бүрэн хариуцах</p> <p>17.Гэрээнд тусгагдсан хугацаанд багтаан барааг нийлүүлэхэд онцгой анхаарах</p> <p>18.Гэрээг Монгол улсад мөрдөгдэж буй хууль тогтоомжийн хүрээнд байгуулах</p> |
|  |  | <p>1. Гэрээг байгуулсан өдрөөс хойш 20,000 /хорин мянга/ тонн угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг тогтсон</p>   |

|    |  |  |
|----|--|--|
| 9  | Ажлын тоо хэмжээ                         | <p>нүүрсний цэгт нийлүүлэх</p> <p>2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд 09-11 дүгээр саруудад нүүрс буух талбайд 20,000 /хорин мянган/ тонн нүүрсний нөөцийг бий болгох</p> <p>3. Нүүрс тээвэрлэх автомашины даац/тн жин/- ыг баталгаажуулан нүүрс тээвэрлэх</p> <p>4. Ухаа худаг дахь “Энержи ресурс” ХХК-ийн нүүрс боловсруулах үйлдвэрээс Даланзадгад сумын нутаг дэвсгэрт байршилтай, өөрийн тусгайлан тохижуулсан нүүрсний цэгт угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг тээвэрлэх, буулгах, сумын Засаг даргын Тамгын газраас олгосон зөвшөөрлийн хуудасны дагуу гаргаллагаатай айл өрх, аж ахуйн нэгж, албан байгууллагын хэрэгцээнд угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг иргэдийн машинд ачих ажлыг хариуцан зохион байгуулах</p> <p>5. Нүүрсний цэгээс ачигдсан угаасан бүхэллэг эсвэл шигшсэн нүүрсийг өөрийн авах цэг хүртэлх ачиж, буулгах зардлыг иргэн өөрөө хариуцна.</p> |
| 10 | Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага | <ul style="list-style-type: none"> <li>- Тусгай зориулалтын авто зам ашиглан, замын ашиглалт, арчилгааг хариуцах</li> <li>- Нүүрсний цэгийг усалгаа хийх асуудлыг бүрэн шийдсэн байх, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байна.</li> </ul>  |

БОЛОВСРУУЛСАН:

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА, ТӨСӨЛ

ХӨТӨЛБӨР ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ..... /Д.ОТГОНБАТ/